"БОДЬТУСГАЛ-АУДИТ" ХХК 'BODITUSGAL-AUDIT' LLC
Харааг бус аудитын байгууллага

Улаанбаатар хот
Баянгол дүүрэг 1дүгээр хороо
"Газар бизнес төв" 305 тоот
Утас: 11305165, 99080074
И-мэйл:boditusgal.audit@gmail.com

2025 оны 02 сарын 10 өдөр

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ГАЗАРКАПИТАЛ ПАРТНЕРС ББСБ" ХХК-ийн УДИРДЛАГАД

Бид "Газаркапитал партнерс ББСБ" ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад нэмэлт тайлбар тодруулгыг баггаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл
Бид энэхүү аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэв.
Уг стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн "Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага" хэсэгт харуулсан болно. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагын дагуу танай байгууллагаас хараат бусаар ажиллах үүргээ бүрэн биелүүлсэн билээ.
Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд
Бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй зүйлсийг аудитын гол асуудлууд гэж үзнэ. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл
Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хамраагүй тул түүнд баталгаажуулалт гаргахгүй.

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг
Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын холбогдох олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь байгууллагын удирдлагын хүлээх үүрэг юм. Энэхүү үүрэгт залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг бүруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулах үүрэг бүхий дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх ажлууд багтана. Удирдлага санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг цаашид тасралтгүй явуулах үүрэг хариуцлага хүлээсэн байна.

Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага
Хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх нь бидний үүрэг хариуцлага юм.
Бид танай байгууллагын санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, түүнийг Аудитын олон улсын стандарт болон Аудитын дотоод стандартыг баримтлан хийв.
Аудит хийхдээ аудитын горим (Шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, тасалбар болголт, тулгах гэх мэт)-уудыг ашиглав.
Байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан бөгөөд цаашид ч уг зарчмыг баримтлах юм байна.

Тайлангийн зориулалт
Энэхүү тайланг "Газаркапитал партнерс ББСБ" ХХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулан бэлтгэв. Бид энэ тайлангийн агуулгын хүрээнд гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Аудиталсан санхүүгийн тайлан, тодруулгыг хавсаргав.

УЛААНБААТАР ХОТ
БОДЬТУСГАЛ-АУДИТ ХХК
ТТ33401 № 5489903

ЗАХИРАЛ З.МЯГМАРСҮРЭН

ГАЗАР
КАПИТАЛ ПАРТНЕРС
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

(мян.төг)

ҮЛДЭГДЭЛИЙН ТЭНЦЭЛ	2024.12.31 **Тайлант үеийн дүн**
Мөнгөн хөрөнгө	970,667
Зээл	23,747,915
ЗЭСан	-568,279
Бусад актив	1,483,487
Үндсэн хөрөнгө	621,813
Хуримтлагдсан элэгдэл	-437,177
НИЙТ ХӨРӨНГӨ	**25,818,426**
Богино хугацаат өглөг	3,000,000
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	7,299,499
Бусад өглөг	946,054
Ердийн хувьцаа	11,500,000
Дахин үнэлгээний сан	1,780
Тайлант үеийн ашиг	3,041,707
Хуримтлагдсан ашиг	29,386
НИЙТ ЭХ ҮҮСВЭР	**25,818,426**

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	
Хүүний орлого	6,461,574
Хүүний зардал	-299,666
Цэвэр хүүний орлого	**6,161,908**
Хүүний бус орлого	353,042
Хүүний бус зардал	-3,057,730
Үйл ажиллагааны ашиг	**3,457,220**
Үйл ажиллагааны бус зардал	-69,951
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	**3,387,270**
Орлогын татварын зардал	-345,562
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	**3,041,707**